

Түүх 2 : Иосеф 1

Библийн эшлэл
[Эхлэл 39:236]

Учир нь ЭЗЭН Иосефтой хамт байж, түүний хийсэн бүхнийг бүтэмжтэй болгожээ.

Иаков арван хоёр хүүтэй байжээ.

Иаков тэдний дундаас арван нэг дэх хүү болох Иосефыг илүү их хайрладаг байв.

Тэрээр хүү Иосефтоо бусад хүүхдүүдээсээ илүү сайхан тансаг дээлийг хийж өмсгөж өгчээ.

Харин ах нар нь дургүйцэж, эцгийн хайрыг илүү хүртсэн Иосефийг үзэн ядаж байлаа.

Иосеф, их зүүд зүүдэлдэг хүү байлаа. Нэгэн өдөр ах нартаа өөрийнхөө зүүдэлсэн зүүдээ ярьж өгөв.

“Ах нар аа! Би өнгөрсөн шөнө зүүд зүүдэллээ. Та бүхний боож тавьсан сүрэл миний боосон сүрлийг тойрон цуглаад түүнд мөргөж байсан. Би бас өөр нэг зүүд зүүдэллээ. Энэ удаа нар, сар бас арван нэгэн од надад мөргөцгөөсөн.”

Гэтэл Иосефийн зүүдийг сонссон ах нар нь түүнд улам ихээр дургүйлхэн үзэн ядаж эхэлсэн.

Мөн эцэг Иаков нь ч бас Иосефийг зэмлэж байв. Гэвч тэрээр Иосефийн үгийг зүрхэндээ хадгалжээ.

Нэгэн өдөр Иаков, Иосефийг хоньдоо хариулахаар явсан ах нар нь сайн байгаа эсэх талаар мэдээд ир хэмээн явуулав.

Харин ах нар нь Иосефийг алах гэсэн боловч Реубен тэднийг болиулсанд тэд түүнийг алсангүй.

Харин Иосефийн бүх хувцасыг тайлаад нүхэнд хаяв.

Ах нар нь Иосефийг Египет уруу явж байсан худалдаачдад хорин мөнгөн зоосоор зарж орхижээ.

Иосефийн өмсөж байсан урт сайхан дээлэнд ямааны цус түрхэв. Тэгээд тэд гэртээ харьцгаан аавдаа түүний хувцасыг үзүүлжээ.

Харин Иосефыг авч явсан худалдаачид Египетэд очоод түүнийг Фараоны түшмэл Потифартад худалджээ.

Тэнд тэрээр үнэнчээр ажиллаж байсан учир Потифарын зарц нарын ахлагч болжээ.

Гэтэл нэг өдөр Иосеф нь Потифарын эхнэрт гүтгэгджээ.

Харин эхнэрийнхээ худал үгэнд үнэмшсэн Потифар Иосефийг хааны хоригдлуудыг хорьдог шоронд хорив.

Иосеф энэ бүхэн худал гэдгийг хэлмээр байсан ч, тэрээр хэнд ч гомдлоо билээ.

Хэдэн өдрийн дараа хааны сөнч болон талхчин хоёр Иосефийн байгаа газарт хоригдов.

Гэтэл нэг өдөр тэр хоёр ихэд баргар царайтай сууж байлаа. Сөнч ингэж хэлэв.





“Би нэг сонин зүүд зүүдэллээ.” гэв.

Гэтэл Иосеф түүний зүүдний тайлалыг хэлж өгөв.

“Гурван өдрийн дараа хааны өршөөлийн зарлиг гарах бөгөөд та суллагдан ордны ажилдаа дахин орох болно. Тэр үед та намайг марталгүй санаарай. Надад энэрэл хайраа үзүүлж хаанд энэ тухай хэлж намайг шоронгоос гаргаж өгнө үү.”

Гээд Иосефыг хэлж дуустал талхчин бас өөрийн зүүдийг ярьж өгөв.

Иосеф талхчины зүүдний тайлалыг ч бас хэлж өгөв.

Үүнээс хойш гурван өдөр өнгөрч, бүх зүйл Иосефийн хэлснээр болов.

Харин хааны сөнч Иосефыг мартаж орхижээ.

Тэр явдлаас хойш хоёр жил өнгөрчээ. Нэгэн өдөр Фараон хаан маш сонин хоёр зүүд зүүдэлжээ.

Хэн ч түүний зүүдийг тайлж чадахгүй байв.

Яг энэ үед хааны сөнч өөрийн зүүдийг тайлж өгсөн Иосефийг гэнэт санав.

Сөнч хаантанд ингэж хэлэв. “Хаантан минь, би зүүд тайлдаг нэгэн мэргэн хүнийг мэднэ.” гэж хэлэв.

Хаан хүн явуулж Иосефийг дуудуулав.

Иосефт Бурханы мэргэн ухаан дүүрэн байсан бөгөөд Фараон хааны зүүдийг тайлж чадахаар байжээ.

Фараон хаан ихэд гайхаж байлаа. Учир нь тэрээр Египетийн ямар ч мэргэдэд байхгүй мэргэн ухаан, түүнд байгааг мэджээ.

Фараон хаан Иосеф болон олон түшмэдийн өмнө ингэж хэлэв.

“Иосеф Бурханы мэргэн ухаанаар дүүрэн хүн юм! Бурхан чамд энэ бүх зүйлийг мэдүүлсэн учир чам шиг мэргэн хүнийг хаанаас олох билээ.” Хаан өөрийн тамгатай бөгжөө гарнаасаа мултлан Иосефт өгөв.

Тэгээд Иосефийг Египетийн сайд болгож улсыг захирах эрхийг өгөв.

Бурхан Иосефт гайхмаар зүүдийг өгсөн бөгөөд эцэст нь тэр зүүдний дагуу биелүүлж өгчээ.

Бурхан Израильчуудыг аврахын тулд Иосефийг Египет уруу явуулж гайхамшигтай ажлаа хийлгэв.

Энэ бүх цаг үеүдийн турш Бурхан үргэлж Иосефтай хамт байсан юм.





Үйл ажиллагаа 1.

Нар, сар бас 11 од зураарай.



Нар



11 од



Сар

- Дараах эшлэлийг дагаж бицээд цээжлээрэй. (Эхлэл 39:236)

Учир нь ЭЗЭН Иосефтой хамт байж



